



**GRATA**  
INTERNATIONAL

**КИБЕР АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ТУХАЙ  
ХУУЛИЙН ХУРААНГУЙ**

GRATA International Mongolia

[www.gratanet.com](http://www.gratanet.com)

## КИБЕР АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬ

Монгол Улсын Засгийн газраас 2021 оны 06 дугаар сарын 30-ны өдөр өргөн мэдүүлсэн Кибер аюулгүй байдлын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг Улсын Их Хурал 2021 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэн баталсан. Уг хууль нь Монгол Улсад анх удаа батлагдаж байгаа бөгөөд сүүлийн арав гаруй жилийн хугацаанд яригдаж, 7 удаа төсөл боловсруулагдаж байжээ.

Аж үйлдвэрийн дөрөвдүгээр хувьсгалд манай улс үндэсний кибер аюулгүй байдлыг хангах эрх зүйн тогтолцоо, улс орны хөгжил, аюулгүй байдалд түлхэц болох, цаашлаад үндэсний аюулгүй байдлын бүрэлдэхүүн хэсэг болох мэдээллийн аюулгүй байдлаа хангах нөхцөлийг бүрдүүлж байгаа амин чухал хуультай болж байна<sup>1</sup>.

Кибер аюулгүй байдлын тухай хууль тогтоомжийг зөрчсөн тохиолдолд хэргийг шалгахдаа хэрэглэх Эрүүгийн хуулийн 26 дугаар бүлгийн нэр томъёо, гэмт хэргийн бүрэлдэхүүн, ойлголтыг Кибер аюулгүй байдлын тухай хууль болон НҮБ-ын Будапештийн конвенцийн дагуу Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсан. Мөн Кибер аюулгүй байдлын тухай хууль батлагдсантай холбогдуулан Зөрчлийн тухай, Харилцаа холбооны тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд холбогдох нэмэлт, өөрчлөлтийг тус тус оруулсан болно.

Бид энэхүү хууль зүйн мэдээгээр Кибер аюулгүй байдлын тухай хуулийн онцлог зохицуулалтуудыг тоймлон хүргэж байна.

### Хуулийн зорилт

Кибер аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны тогтолцоо, зарчим, эрх зүйн үндсийг тогтоох, кибер орон зай, кибер орчин дахь мэдээллийн бүрэн бүтэн, нууцлагдсан, хүртээмжтэй байдлыг хангахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

### Хуулийн үйлчлэх хүрээ

Кибер аюулгүй байдлыг хангахтай холбоотой төр, хүн, хуулийн этгээдийн хооронд үүсэх харилцааг уялдуулах зохицуулах, зохион байгуулах, хяналтыг хэрэгжүүлэх харилцаанд үйлчилнэ.

Хуульд өөрөөр заагаагүй бол Монгол Улсын мэдээллийн систем, мэдээллийн сүлжээгээр дамжуулан үйл ажиллагаа явуулж байгаа гадаадын иргэн, харьяалалгүй хүн, гадаадын болон гадаадын хөрөнгө оруулалттай хуулийн этгээдэд энэ хууль нэгэн адил үйлчилнэ.

### Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

*“Кибер аюулгүй байдал”* - кибер орчинд мэдээллийн бүрэн бүтэн, нууцлагдсан хүртээмжтэй байдал хангагдсан байхыг хэлнэ;

*“Кибер орон зай”* - интернет болон бусад мэдээлэл, харилцаа холбооны сүлжээ, тэдгээрийн ажиллагааг хангах мэдээллийн дэд бүтцийн харилцан хамааралтай цогцоос бүрдсэн биет болон биет бус талбар;

*“Кибер орчин”* - мэдээлэлд хандах, нэвтрэх, цуглуулах, түүнийг боловсруулах, хадгалах, ашиглах боломж олгож байгаа мэдээллийн систем, мэдээллийн сүлжээний орчныг;

*“Кибер халдлага”* - мэдээллийн систем, мэдээллийн сүлжээний кибер аюулгүй байдлыг алдагдуулах зорилго бүхий үйлдлийг;

*“Кибер аюулгүй байдлын зөрчил”* - мэдээллийн системийн бүрэн бүтэн, нууцлагдсан, хүртээмжтэй байдалд заналхийлж байгаа аливаа үйлдэл, эс үйлдлийг;

<sup>1</sup> <http://parliament.mn/n/mo3on>

*“Кибер халдлага, зөрчилтэй тэмцэх төв”*- кибер халдлага, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, таслан зогсоох, хариу арга хэмжээ авах, мэдээллийн системийг нөхөн сэргээх үйл ажиллагааг зохицуулж, мэргэжлийн удирдлагаар хангах үндсэн чиг үүрэг бүхий этгээдийг;

*“Кибер аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээ”* - цахим мэдээлэл, мэдээллийн систем, мэдээллийн сүлжээний кибер аюулгүй байдал алдагдах, аюул занал тохиолдох магадлал, эмзэг байдлын түвшин, түүнээс үүсэх үр дагавар, эрсдэлийг бууруулах, урьдчилан сэргийлэх арга хэмжээг тодорхойлох мэргэшсэн үйл ажиллагааг;

*“Онц чухал мэдээллийн дэд бүтэцтэй байгууллага”*- кибер аюулгүй байдал алдагдсанаар хэвийн үйл ажиллагаа нь доголдож Монгол Улсын үндэсний аюулгүй байдал, нийгэм, эдийн засагт хохирол учруулж болох мэдээллийн систем, мэдээллийн сүлжээ бүхий байгууллагыг;

*“Үндэсний хэмжээний кибер халдлага”*- онц чухал мэдээллийн дэд бүтэцтэй байгууллагын мэдээллийн систем, мэдээллийн сүлжээнд халдсаны улмаас тухайн байгууллагын хэвийн үйл ажиллагааг алдагдуулж, Монгол Улсын үндэсний аюулгүй байдал, нийгэм, эдийн засагт хохирол учруулахуйц кибер халдлагыг;

*“Төрийн мэдээллийн нэгдсэн сүлжээ”*- төрийн байгууллага хоорондын мэдээлэл солилцох, кибер аюулгүй байдлыг хангахад чиглэсэн нэгдсэн дэд бүтэц бүхий төрийн интернэт хэрэглээ, албан болон тусгай хэрэглээний сүлжээний цогцыг;

#### **Кибер аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны чиглэл:**

- кибер аюулгүй байдлын бодлого, удирдлага, зохион байгуулалт
- кибер аюулгүй байдлыг хангах техник, технологийн арга хэмжээ;
- кибер халдлага, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх арга хэмжээ;
- кибер халдлага, зөрчлийг илрүүлэх, таслан зогсоох, хариу арга хэмжээ авах, нөхөн сэргээх арга хэмжээ.

#### **Кибер аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээ**

- Кибер аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээг цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад бүртгүүлсэн хуулийн этгээд хийнэ. Уг хуулийн этгээд нь олон улсын мэргэжлийн холбоо, стандартын байгууллага, эсхүл түүнтэй дүйцэхүйц байгууллагаас олгосон хүчин төгөлдөр гэрчилгээ бүхий орон тооны ажилтантай байна.
- Кибер аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээ хийх журам, аргачлалыг цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тагнуулын байгууллагатай хамтран батална.

#### **Мэдээллийн аюулгүй байдлын аудит**

Мэдээллийн аюулгүй байдлын аудитыг цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад бүртгүүлсэн хуулийн этгээд хийнэ. Мэдээллийн аюулгүй байдлын аудит хийх хуулийн этгээд нь:

- олон улсын мэргэжлийн холбоо, стандартын байгууллага, эсхүл түүнтэй дүйцэхүйц байгууллагаас олгосон мэдээллийн аюулгүй байдлын аудит хийх хүчин төгөлдөр гэрчилгээ бүхий орон тооны ажилтантай байх;
- ажилтан ижил төрлийн аудит хийх эрх бүхий бусад хуулийн этгээдэд зэрэгцсэн гэрээгээр ажилладаггүй байх;
- хуульд заасан бусад шаардлага.

## КИБЕР АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ ТОГТОЛЦОО

<b>Засгийн газар</b>	<ul style="list-style-type: none"> <li>• Кибер аюулгүй байдлын үндэсний стратегийг батлах;</li> <li>• Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт кибер аюулгүй байдлыг хангах талаар тусгах, хууль тогтоожмийн биелэлтийг зохион байгуулах;</li> <li>• Онц чухал мэдээллийн дэд бүтэцтэй байгууллагын жагсаалтыг батлах;</li> </ul>
<b>Кибер аюулгүй байдлын зөвлөл</b>	<ul style="list-style-type: none"> <li>• <b><i>Зөвлөлийг Ерөнхий сайд тэргүүлж, дэд даргаар цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, Тагнуулын ерөнхий газрын дарга нар ажиллана;</i></b></li> <li>• Кибер аюулгүй байдлыг хангах хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавина;</li> <li>• Үндэсний хэмжээний кибер аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааг нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангах, холбогдох байгууллагын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах;</li> </ul>
<b>Цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага</b>	<ul style="list-style-type: none"> <li>• Кибер аюулгүй байдлыг хангах хууль тогтоомж, эрх бүхий байгууллагын шийдвэрийг хэрэгжүүлэх;</li> <li>• Кибер аюулгүй байдлыг талаар хөгжлийн бодлого боловсруулах, хэрэгжилтийг зохион байгуулах;</li> <li>• Кибер аюулгүй байдлыг хангах нийтлэг журмыг тагнуулын байгууллага, зэвсэгт хүчний кибер аюулгүй байдлыг хангах байгууллагатай хамтран боловруулах;</li> </ul>
<b>Тагнуулын байгууллага</b>	<ul style="list-style-type: none"> <li>• Төрийн мэдээллийн нэгдсэн сүлжээг зохион байгуулж, түүний кибер аюулгүй байдлыг хангах;</li> <li>• Төрийн мэдээллийн нэгдсэн сүлжээнд холбогдсон болон онц чухал мэдээллийн дэд бүтэцтэй төрийн өмчит хуулийн этгээдийн кибер аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаанд хяналт тавих, холбогдох этгээдэд сургалт зохион байгуулах;</li> <li>• Үндэсний хэмжээний кибер халдлагаас хамгаалах төлөвлөгөөг боловсруулах, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах;</li> </ul>
<b>Зэвсэгт хүчний аюулгүй байдлыг хангах байгууллага</b>	<ul style="list-style-type: none"> <li>• Кибер аюулгүй байдлын хууль тогтоомжийн хэрэгжилтийг батлан хамгаалах салбарт зохион байгуулах;</li> <li>• Тайван цагт батлан хамгаалах үйл ажиллагааны кибер аюулгүй байдал, зэвсэгт хүчний мэдээллийн систем, мэдээллийн сүлжээний аюулгүй байдлыг хангаж, шаардлагатай үед улсын кибер орон зайн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх;</li> </ul>
<b>Цагдаагийн байгууллага</b>	<ul style="list-style-type: none"> <li>• Кибер халдлага, зөрчилтэй холбоотой гэмт хэргийн мэдээллийг хүлээн авч, хуульд заасан ажиллагааг явуулах, үүнтэй холбоотой чиг үүргээ хэрэгжүүлэхэд шаардлагатай мэдээллийг холбогдох төрийн байгууллага, албан тушаалтан, хүн, хуулийн этгээдээс гаргуулах авах;</li> <li>• Кибер аюулгүй байдлыг хангах асуудлаар хүн, хуулийн этгээдэд зөвлөмж, шаардлага, сэрэмжлүүлэг хүргүүлэх;</li> </ul>
<b>Төрийн өмчит хуулийн этгээд</b>	<ul style="list-style-type: none"> <li>• Кибер аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны дотоод журам батлах;</li> <li>• Кибер аюулгүй байдлыг хангах талаар эрх бүхий байгууллагаас өгсөн зөвлөмж, шаардлагыг биелүүлэх;</li> <li>• Кибер халдлага, зөрчилд өртсөн, өртсөн байж болзошгүй тохиолдолд кибер халдлага, зөрчилтэй тэмцэх холбогдох төвд даруй мэдэгдэх;</li> </ul>
<b>Хуулийн этгээд</b>	<ul style="list-style-type: none"> <li>• Кибер аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны дотоод журам батлах;</li> <li>• Кибер халдлагын талаар кибер халдлага, зөрчилтэй тэмцэх холбогдох төвд даруй мэдэгдэх, таслан зогсоох боломжгүй бол туслалцаа авах;</li> </ul>
<b>Иргэн</b>	<ul style="list-style-type: none"> <li>• Өөрийн болон өөрийн асрамжид байгуу хүний кибер аюулгүй байдлыг хариуцах;</li> <li>• Холбогдох байгууллагаас гаргасан зөвлөмжийг дагах, шаардлагыг биелүүлэх</li> </ul>



**Үндэсний төв**

**Нийтийн төв**

**Зэвсэгт хүчний төв**

*Үндэсний төв* тагнуулын байгууллагын бүтцэд ажиллана.

- Үндэсний төв нь улсын хэмжээнд кибер халдлага, зөрчилтэй тэмцэх төвүүдийн үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх;
- Эрхлэх асуудлын хүрээнд Монгол Улсыг төлөөлөн олон улсын болон гадаад улсын ижил төстэй байгууллагатай мэдээ, мэдээлэл солилцох, хамтран ажиллах;
- Кибер халдлага, зөрчлийн талаар мэдээлэл хүлээн авах, холбогдох байгууллагад шилжүүлэх;
- Онц чухал мэдээллийн дэд бүтэцтэй байгууллага, холбогдох бусад байгууллага, албан тушаалтанд кибер халдлага, зөрчлийн талаар зөвлөмж, шаардлага хүргүүлэх;
- Улсын хэмжээнд бүртгэгдсэн кибер халдлага, зөрчлийн талаарх мэдээллийг ангилах;

*Нийтийн төв* цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дэргэд ажиллана.

- Нийтийн төв нь иргэн, хуулийн этгээдийн мэдээллийн систем, мэдээллийн сүлжээнд чиглэсэн кибер халдлага, зөрчлийг илрүүлэх, таслан зогсоох, хариу арга хэмжээ авах, кибер халдлага, зөрчилд өртсөн мэдээллийн системийг нөхөн сэргээхэд дэмжлэг үзүүлэх;
- Кибер халдлага, зөрчлийн талаар судалгаа, дүн шинжилгээ хийх, олон нийтэд зөвлөмж, мэдээлэл түгээх;
- Бусад төвүүдтэй хамтран ажиллах
- Иргэн, хуулийн этгээдэд кибер халдлага, зөрчлийн талаар зөвлөмж, шаардлага хүргүүлэх ;

Зэвсэгт хүчний кибер аюулгүй байдлыг хангах байгууллагын бүтцэд *Зэвсэгт хүчний төв* ажиллана.

- Зэвсэгт хүчний төв нь батлан хамгаалах салбарын мэдээллийн системд чиглэсэн кибер халдлага, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, таслан зогсоох, хариу арга хэмжээ авах, кибер халдлага, зөрчилд өртсөн мэдээллийн системийг нөхөн сэргээх;
- Гадны кибер халдлага, түрэмгийллээс хамгаалах үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх;
- Гадаад, дотоодын ижил чиг үүрэгтэй байгууллагуудтай мэдээ, мэдээлэл солилцож, хамтран ажиллах;
- Батлан хамгаалах салбарын кибер аюулгүй байдлыг хангах зориулалттай техник болон программ хангамжийг шалган баталгаажуулах, дүгнэлт гаргах;

**Кибер аюулгүй байдлын хууль тогтоомж зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага**

- Энэ хуулийг зөрчсөн тохиолдолд Зөрчлийн тухай хуулийн 14.13 дугаар зүйлд заасны дагуу хуулийн этгээд 300,000-10,000,000 төгрөгийн торгууль төлнө.
- Эрүүгийн хуулийн 26 дугаар зүйлд заасны дагуу гэмт хэргийн бүрэлдэхүүнээс хамаарч 2,700,000-40,000,000 төгрөгийн торгууль төлөх эсхүл 6 сараас 2 жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл 6 сараас 12 жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.
- Энэ хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хууль эсхүл Хөдөлмөрийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

**Эх сурвалж:**

<https://legalinfo.mn/mn/detail?lawId=16390365491061> – “Кибер аюулгүй байдлын тухай хууль”

<https://legalinfo.mn/mn/detail/12695> - “Зөрчлийн тухай хууль” /2017/

<https://legalinfo.mn/mn/detail/11634> - “Эрүүгийн тухай хууль” /2015/

<http://parliament.mn/n/mo3on> - “Инфографик: Кибер аюулгүй байдлын тухай хуулийн танилцуулга”

**Дэлгэрэнгүй мэдээлэл авах эсвэл асуулт байвал ГРАТА Интернэшнл хуулийн фирмийн Партнер В.Болормаагийн [bvolodya@gratanet.com](mailto:bvolodya@gratanet.com) хаягаар эсвэл 976 70155031 утсаар холбоо барина уу.**

*Дэлхийн 20 улсад салбартай олон улсын хуулийн фирм ГРАТА Интернэшнлийн Монгол дах оффис болох Өмгөөллийн “ГРАТА Интернэшнл Монголиа” ХХН энэхүү хууль зүйн мэдээллийг бэлтгэсэн. Энэхүү хуулийн зүйн мэдээлэл нь ерөнхий мэдээлэл өгөх зорилготой бөгөөд тодорхой асуудалд нарийвчлан дүн шинжилгээ хийгээгүй болно. Энэхүү хууль зүйн мэдээллийг уншигч нь ямар нэгэн үйлдэл хийхээсээ өмнө өөрсдийн нөхцөл байдалд тохирсон мэргэжлийн зөвлөгөө авах хэрэгтэй. Энэхүү хууль зүйн мэдээллийг ашигласны улмаас үүссэн аливаа үр дагавар, хохирлыг бид хариуцахгүй.*